



## ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/62

Улаанбаатар хот

### Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангуулах байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгоор байгууллагын албан ёсны нийгмийн мэдээллийн сүлжээ /Meta-/Facebook boost хуудсыг идэвхжүүлэх, албан хэрэгцээнд хэрэглэгдэх цахим график дизайн, постер, танилцуулга бэлтгэх веб программ /Canva/ ашиглахтай холбоотой зардлыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 600,000 (Зургаан зуун мянга) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (Б.Түмэнжин)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-т даалгасугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ